

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХЭЛТСИЙН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ, ӨГӨГДӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
МӨНХЖАРГАЛЫН НОМИНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
Зорилт 1. “НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ, ӨГӨГДЛИЙН ТАЛААРХ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.	Арга хэмжээ 1.1. Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдөл нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлагнах	Тайлангийн тоо	-	1	“Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 5.3 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана” гэж заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/141 тоот албан бичгийг “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-аар батлагдсан 57 байгууллага руу хүргүүлснээс 31 байгууллага нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж ирүүлсэн. Тус журмын 5.4 дэх заалтад “Энэ журмын 5.3-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу тайланг нэгтгэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024.01.15 - 2024.12.05	100%	
2.	Арга хэмжээ 1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны нээлттэй өгөгдөл нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах	Төлөвлөгөөний төслийн тоо	-	1	Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 200 дугаар тогтоолоор баталсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 5.3 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана” гэж заасны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/94 дугаар тушаалаар “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны нээлттэй өгөгдлийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх тухай” төлөвлөгөөг батлуулсан.	2024.01.15 - 2024.03.30	100%	

3.	Арга хэмжээ 1.3. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №24. Нээлттэй өгөгдлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1182 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан 2024 оны 7 сарын 19-ний ХЭГ/1298 дугаар албан бичгээр хэлэлцүүлэх тогтоолын төсөлд дахин санал авах тухай хариу ирүүлсний дагуу 8 сарын 14-ний 01/128 албан тоотоор Засгийн газрын гишүүдээс тогтоолын төсөлд санал авах тухай бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 9 сарын 25-ны хуралдаанаар "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах нийтэд ил болгох төрийн 691 нээлттэй өгөгдлийн жагсаалтыг танилцуулж, шинэчлэн батлуулсан.	2024.01.15 - 2024.06.30	100%
4.	Арга хэмжээ 1.4. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №14. "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	"Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг судлан боловсруулж, нэгжийн даргад танилцуулсан. Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлж, тус системд "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх" журмын 4 шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагуудын нээлттэй мэдээллийн үнэлгээг үнэлж байна.	2024.04.01 - 2024.06.30	70%

5.	Арга хэмжээ 1.5. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын хэрэгжилтийг хангах	Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд нээлттэй өгөгдлийг сайтад оруулан, шинэчилсэн тоо	502	1000	Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “Opendata.gov.mn”-ын 2.0 хувилбарыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хуучин сервисээс зөвхөн машинд уншигдах форматтай өгөгдлийг хөрвүүлж 2024 оны 12 сарын 10-ны өдрөөс өнөөдрийн байдлаар 16288 удаа өгөгдөл татагдаж 52 байгууллагын 2383 бүрдлийг байршуулсан байна.	2024.01.15 - 2024.12.05	100%
----	--	--	-----	------	---	-------------------------------	------

Зорилт 2. “НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ, АШИГЛАЛТЫГ ОНОВЧТОЙ БОЛГОХ, ТЕХНОЛОГИ-ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭХ, НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ, ӨГӨГДЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Арга хэмжээ 2.1. Нээлттэй өгөгдлийн талаар сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан тоо	-	1	1.Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ын шинэчилсэн 2.0 хувилбар дээр хэрхэн өгөгдлөө байршуулах талаар мэдээлэл хариуцагч нарт 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр сургалтыг цахимаар зохион байгуулсан. Тус сургалтаар системд тоон гарын үсгээр нэвтрэх, нээлттэй өгөгдлөө хугацаандаа нийтлэх, машинд уншигдах формат зэрэг мэдээлэл өгч, нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагчдаас санал, асуулга авч ажилласан. Сургалтад хамрагдаж амжаагүй албан хаагч нарт видео зааварчилгааг хүргүүлсэн. 2.НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн хамтын ажиллагааны асуудал хариуцсан газар (UNDESA) нь Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллийг оролцуулсан “Монгол Улсын Үндэсний өгөгдлийн засаглалын тогтолцоо болон дижитал засаглал” сэдэвт Олон Улсын хурлыг 2024 оны 12 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд "Блю-Скай" зочид буудлын Кристал хурлын танхимд зохион байгуулсан.	2024.01.15 - 2024.06.10	100%
----	---	-----------------------	---	---	--	-------------------------------	------

2.	Арга хэмжээ 2.2. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн хувилбар	1.0 хувилбар	2.0 хувилбар	1.Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “Opendata.gov.mn”-ын 2.0 хувилбарыг 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдөр эхлэн нэвтрүүлсэн. Тус порталын виртуал машин (VPS) дээр байршуулах ажил хийгдэж байна. 2.“Нээлттэй өгөгдлийн жагсаалт” дахь мэдээлэл хариуцагч байгууллагуудын нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагч нарт 2024 оны 2 сарын 07-ны өдөр цахимаар сургалт зохион байгуулсан. 3.Тус 2.0 хувилбарыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хуучин сервисээс зөвхөн машинд уншигдах форматтай өгөгдлийг хөрвүүлж өнөөдрийн байдлаар 52 байгууллагын 2350 бүрдлийг байршуулаад байна. opendata.gov.mn	2024.01.15 - 2024.12.05	100%
3.	Арга хэмжээ 2.3. Нээлттэй мэдээллийн нэгдсэн платформ /shilen.gov.mn/-д мэдээлэл байршуулах ажлыг зохион байгуулах	Shilen.gov.mn системд байршуулсан нээлттэй мэдээллийн тоо	-	1	1.Нээлттэй мэдээллийн нэгдсэн платформ /shilen.gov.mn/ 2.0 системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 01/817 тоот албан бичгийг ЗГ-ын гишүүд, Аймаг, Нийслэлийн ЗД нарт, шил ажиллагааны хүрээнд хамтран ажилласан 123 байгууллагын 257 албан хаагч нарт цахим шуудангаар хүргүүлж, 2024.12.05-ны өдрийн байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 1239 байгууллагын 1490 албан хаагчдад үүсгэж, 6 удаагийн сургалтад хамруулсан. 2.Хуульд заасан байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллээ мэдээлэл хариуцагч байгууллага байршуулах, үнэн зөв байдлыг хариуцах, шууд холбох боломжийг бүрдүүлсэн ба үндсэн систем ХУР, тусгай зөвшөөрлийн licence.mn системүүдийг холбосон.	2024.01.15 - 2024.12.05	100%
4.	Арга хэмжээ 2.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг албан ёсны цахим хуудаст байршуулсан эсэхэд үнэлгээ хийх	Үнэлгээний тоо	135	34	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн байгууллагын нээлттэй мэдээллийн үнэлгээг тухай бүр шинэчлэх, илгээх нөхцөлийг бүрдүүлэхээр “Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан 68 нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж “Шилэн Индекс”-ийг тухай бүр нийтэлж байна. Өнөөдрийн байдлаар Төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон Нутгийн захиргааны нийт 175 байгууллагын тайланг үнэлэн, хянан үзэж баталгаажуулаад байна. www.shilen.gov.mn	2024.01.15 - 2024.12.05	100%

Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”

1.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо - 1 ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу биелэлтийг гаргасан.	2024.01.15 - 2024.12.05	100%
2.	Арга хэмжээ 3.2. Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	-Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем “shilen.gov.mn” системийн 2.0 хувилбарын хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийг хангаж, 21 аймгийн хэмжээнд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 53 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. -А/186 болон А/233 тушаалын худалдан авах ажиллагааны 11 тендерийн баримт бичгийг архивлан 2024 оны 2 сарын 07-ны өдөр аудитор (н.Болормаа)-д хүлээлгэн өгсөн. -Залуучуудад зориулсан дижитал ажлын байрыг бий болгох хөтөлбөр боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 2 сарын 07-ны өдөр батлуулсан. -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахим шилжилтийн талаар соён гэгээрүүлэх контент боловсруулах үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 2 сарын 09-ний өдөр батлуулсан. -Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан 4.1-ийн зорилтын 4.1.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. гэж заасны хүрээнд Нээлттэй өгөгдлийн порталыг өргөтгөлийн ажлын тайланг ЗГХЭГ аудитор (н.Мөнхшагай)-д нотлох баримтын хамт өгсөн. -Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/69 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/66 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024.01.15 - 2024.12.05	100%

					-“Мэдээллийн хэрэгслийн технологи, үйл ажиллагааны онцлогийг таниулан сурталчлах хүрээнд контент бүтээх” ЦХХХЯ/20240603199 дугаартай үйлчилгээний ажлыг 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн Номад трейд ХХК-тай уг үнийн дүнгээр гэрээ байгуулсан.		
3.	Арга хэмжээ 3.3. Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх	Хэрэгжилтээр	Хэрэгжилтээр	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2-т заасны дагуу “Зөвлөлийн үйл ажиллагааны 2024 оны хагас жилийн төлөвлөгөө”, “Үнэлгээний хуваарь”-ийг батлуулсан.	2024.01.15 - 2024.12.05	100%
4.	Арга хэмжээ 3.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	1	Хэрэгжилтээр	Тус яамны 2023 оны худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулсан А/186, А/233 тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны худалдан авах үйл ажиллагааны 11 хавтас материалыг архивлан Төрийн захиргааны удирдлагын газрын Архив-бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.	2024.01.15 - 2024.12.05	100%
5.	Арга хэмжээ 3.5 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол,	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо	Хэрэгжилтээр	Хэрэгжилтээр	1. Иргэн О.Шинэбаяраас Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрыг яаралтай цахим шилэн болгож өгөх, хандивын зарцуулалтыг ил тод болгох гомдлыг Хүүхдийн төлөө сангийн орлого, зарлагын мэдээллийг Төрийн нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ээс харах боломжтой талаар иргэнд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр утсаар мэдээлэл өгсөн. 2. Иргэн С.Оюунсоёмбоос 2024 оны 04 сарын 11-ний өдөр төрийн нэгдсэн судалгааны платформ ажиллуулж байгаа нь сайшаалтай байгаа ч байгууллагууд судалгаагаа цаг тутамд	2024.01.15 - 2024.12.05	100%

	санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ				шинэчилж оруулахгүй байгаа талаар ирүүлсэн гомдлыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нарт 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хуулийн хэрэгжилтийг хангах тухай 03/745 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
6.	Арга хэмжээ 3.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо	ХАСХОМэдү үлэг - 1 Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо-хэрэгжилтээр	Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо-хэрэгжилтээр	Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягтыг баталгаажуулж Захиргааны эрх зүйн асуудал хариуцсан шинжээч (Б.Солонго)-д хүргүүлсэн.	2024.01.15 - 2024.12.05	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд	Өгсөн үүрэг даалгаврын тоо		Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг хангах	Үндэсний судалгааны нэгдсэн платформ (sudalгаа.gov.mn)-д 2024 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 1852 судалгааг мэдээлэл хариуцагч байгууллагууд байршуулсан байна. Судалгааны нэгдсэн платформын хэрэглэгчийн гарын авлагыг шинэчлэн тус платформд байршуулсан. sudalгаа.gov.mn.	2024.01.15-2024.12.15	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна.	-	1	Цахим шилжилтийн үйл ажиллагаанд хиймэл оюуны хэрэглээг нэвтрүүлэх, салбар хоорондын уялдааг хангах зорилгоор төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, И-Монгол академи УТҮГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон Мэдээллийн технологийн үндэсний паркийн инкубаторын компаниудын төлөөлөл болох нийт 60 албан хаагчдад “Хиймэл оюун ухааны хэрэглээ, хэрэгжилт, цаашдын чиг хандлага” сэдвээр 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Мэдээллийн технологийн үндэсний парк дээр мэдлэг хуваалцах семинар /workshop/-ыг зохион байгуулсан. -БНХАУ-ын Худалдааны Яамнаас зохион байгуулсан “Дэлхийн тогтвортой хөгжил - Хил дамнасан цахим худалдаагаар ядуурлыг бууруулах” сургалт нь 2024 оны 9 сарын 17-ны өдрөөс 2024 оны 10 сарын 03-ны өдрүүдийн хооронд БНХАУ-ын Ханжой хотын Жейжанг мужид зохион байгуулагдаж, тус сургалтад хамрагдсан.	2024.01.15- 2024.12.05	100%
2.	Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох	Сургалт, хурал, семинарт оролцсон байна.	-	2	-Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг "7:4:10" арга зүйн сургалтад тогтмол хамрагдсан. -Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “AI EdTech Mongolia 2024” арга хэмжээнд оролцож, туршлага судалсан.	2024.01.01- 2024.12.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нээлттэй өгөгдөл, нээлттэй мэдээлэл /М.Номин /
хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)